



The best
**Corporate
Banking**
in Mongolia



Financial • Manager's • Convention

ШИЛДЭГ
САНХҮҮЧДИЙН
ШИРЭЭНИЙ НОМ

Монгол Улсын эдийн засгийн цохилох зүрх хөгжлийг түүчээлэгч аж ахуйн нэгжийн удирдлага, шилдэг санхүүч та бүхний энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье!

Бизнесийн талбарт шинэчлэлтийг эхлүүлэхэд гол нөлөө үзүүлэх манлайлагч та бүхэнд зориулан хэрэгцээт мэдээ, мэдээллийг агуулсан “Илүү сайнаар бүтээе” уриатай FMC арга хэмжээний хүрээнд Голомт банкны шинжээчдийн бэлтгэсэн 2021-2022 оны макро эдийн засгийн төлөв байдлын талаарх судалгаа, мэдээллийг хүргэж байгаадаа таатай байна.

Та энэхүү номоос голлох түүхий эдийн зах зээлийн нөхцөл байдал, цаашдын хандлага, цар тахлын нөлөө болон түүний эсрэг хэрэгжүүлж буй сангийн болон мөнгөний бодлого, түүнчлэн бодит эдийн засгийн өсөлт, түүхий эдийн зах зээл, мега төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой юм.

Мэдээлэлтэй хүн илүү олон боломжийг олж хардаг. Бидний өгч буй мэдээллийг та өөрийн туршлагатай хослуулан өнгөрснөөс илүү сайхан ирээдүйг бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон харилцагч таны шийдвэр мэргэн байг.

Хүндэтгэсэн,
З.Мягмардорж
Байгууллагын банкны газрын захирал

АГУУЛГА

1. ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- Түүхий эдийн зах зээл
- Цар тахлын нөлөө
- Бодит эдийн засаг

2. САНГИЙН БОЛОН МӨНГӨНИЙ БОДЛОГО

- Сангийн бодлого
- Мөнгөний бодлого

3. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД

- Уул уурхай
- Худалдаа
- Үйлчилгээ
- Үйлдвэрлэл
- Барилга
- Тээвэр

4. ИРЭЭДҮЙН ХҮЛЭЭЛТ

- Түүхий эдийн зах зээл
- Сангийн болон мөнгөний бодлого
- Мега төслүүд
- Эдийн засгийн өсөлт
- Нэгтгэл

5. “АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН БИЗНЕС ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ КОРОНАВИРУСЫН НӨЛӨӨЛӨЛ” СУДАЛГАА 2021

- Хураангуй дүгнэлт
- Судалгааны танилцуулга
- Бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөө
- ААНБ-уудын санхүүгийн үзүүлэлтүүд
- Хүний нөөцөд гарсан өөрчлөлт
- Засгийн газрын бодлогын нөлөө
- Иргэдийн сегмент дэх нөлөө

1


ЭДИЙН
ЗАСГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ



ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс нь дэлхийн хүчирхэг хоёр эдийн засаг болох ОХУ болон Хятад улсын дунд орших далайд гарцгүй улс юм. Мөн түүнчлэн газрын доорх баялаг, тэр дундаа нүүрс болон зэсийн арвин нөөцтэй, үйлдвэржилт өндөр төвшин хөгжөөгүй учир эдийн засгийн гол тулгуур нь уул уурхайн салбарын түүхий эдийн экспорт юм.

Гадаад худалдааны тэнцэл




Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн 7 жилийн дунджаар авч үзэхэд нийт экспортын 89%-ийг түүхий эдийн экспорт бүрдүүлж байгаа бол нийт түүхий эдийн экспортын 75%-ийг зэс, нүүрс, төмрийн экспорт дангаар бүрдүүлж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт экспортын 72.5%-ийг Хятад улс руу экспортолсон бол нийт импортын 62.1%-ийг Хятад болон ОХУ-ууд бүрдүүлж байна (Монголын Гааль, 2021). Тийм ч учраас Монгол Улсын эдийн засаг Хятад болон ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал болон дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнээс шууд хамааралтай байдал билээ.


6

Цар тахалтай холбоотойгоор 2020 онд иргэд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, худалдаа үйлчилгээний салбар үйл ажиллагаагаа зогсооход хүргэсэн нь нийт импортыг 2019 онтой харьцуулахад 13.6% бууруулсан байна. Орос болон Саудын Араб улсын хооронд үүссэн үнийн дайнтай холбоотой газрын тос, шатахууны үнэ 2020 оны 1-р улиралд 65% буурсан нь мөн энэхүү бууралтад түлхэц үзүүлсэн. Цар тахал нь цор ганц Монгол Улс гэлтгүй дэлхийн улс орнууд, тэр дундаа Хятадын үйлдвэрлэл, эрэлтэд сөргөөр нөлөөлсөн нь 2020 онд нүүрсний үнэ огцом буурахад хүргэсэн. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдал үүсэж, улс орнууд эдийн засгаа сэргээх мөнгөний зөөлөн бодлого авч хэрэгжүүлсний үр дүнд ам долларын өгөөж буурч, энэ нь хөрөнгө оруулагчдыг алт худалдан авахад хүргэсэн нь алтны үнийг 2020 онд тухайн оны эхнээс 25.7%-аар өсгөж өгсөн нь Монгол Улсын нийт экспортыг 2020 онд өндөр бууралт үзүүлэхээс сэргийлсэн байна.

Түүхий эдийн улирлын дундаж үнэ



Түүхий эдийн улирлын дундаж үнэ



Эх сурвалж: OYBC


Харин дэлхийн хамгийн томоохон зэсийн экспортлогч орнууд болон Чили болон Перу улсад болсон цар тахалтай холбоотой нийлүүлэлтийн бууралт нь зэсийн үнийг тогтвортой хадгалагдахад дэм болсон нь мөн манай улсын экспортод эерэгээр нөлөөлжээ. Ийнхүү 2020 онд импорт 13.6%-иар буурсан боловч экспорт 0.6% буурсан нь худалдааны тэнцлийг 2.3 тэрбум доллар болгон өсгөжээ.

7

Тэгвэл 2021 он гарснаас хойш дэлхий нийтэд вакцинжуулалт идэвхтэй хийгдэж эхэлсэн ба энэ нь үйл ажиллагаагаа зогсоогоод байсан ААНБ-ад үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлж, 2020 онд 3.5% буураад байсан дэлхийн эдийн засаг (Дэлхийн банк, 2021) аажмаар сэргэж эхэлсэн билээ. Тэр дундаа Хятадын эдийн засаг 2021 оны эхний хагас жилийн байдлаар 12.8% өссөн байна. Эдийн засаг сэргэхийг дагаад түүхий эдийн эрэлт өсдөг. Хятадын эдийн засгийн өсөлтийг дагаад нүүрсний үнэ 2021 оны 8-р сард оны эхэн үетэй харьцуулахад 115.4% өссөн бол зэсийн үнэ 20.6% өсжээ. Ийнхүү уул уурхайн түүхий эдийн гол бүтээгдэхүүний үнэ бүгд өсөлттэй байгааг эдийн засагчид уул уурхайн супер цикл эхэлсэн хэмээн дүгнэж байна. Супер циклтай холбоотой 2021 он гарснаас хойш экспортын орлого сар бүр өмнөх оны мөн үеүүдтэй харьцуулахад 45%-93% өсөлт үзүүлж байсан нь маш ховор тохиолдох үзэгдэл юм. Гэсэн хэдий ч Монгол улс 2020 оны сүүлээр цар тахлыг дотооддоо алдаж, өдөрт илрэх тохиолдлын тоо 2021 онд улам өссөн нь Хятад талаас хилийг хаах, хил дээр тавигдах шаардлагыг өндөр болгосон арга хэмжээнүүдийг авч, энэ нь экспортын гарцад сөргөөр нөлөөлж байна. 2021 оны 2-р улиралд өдөрт хилээр гарах чингэлэгний тоо энгийн үеэс 10 дахин буурсан нь экспортын өсөлтийн хурд саарахад хүргэсэн ба хөл хориотой холбоотой бизнесээ зогсоогоод байсан ААНБ-ын үйл ажиллагаа сэргэхийг дагаад импортын эрэлт нэмэгдэж, импортын өсөлт нэмэгдэх хандлагатай болсон.

Ийнхүү цар тахал, хөл хорио, ААНБ-уудын үйл ажиллагааны доголдол, эдийн засгийн идэвхгүй байдал зэрэг сөрөг нөлөөллүүд 2020 онд бодит эдийн засаг 4.6%-иар агшихад хүргэв.


Бодит эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: УСХ

* - Энэхүү БДНБ-г тооцохдоо 2015 он суурийг ашигласан ба 2010 он суурь бүхий БДНБ-с тооцсон өсөлтөөс ялгаатай болно.

Бодит эдийн засгийн өсөлт, (салбараар)



Эх сурвалж: УСХ

* - Энэхүү БДНБ-г тооцохдоо 2015 он суурийг ашигласан ба 2010 он суурь бүхий БДНБ-с тооцсон өсөлтөөс ялгаатай болно.

Тэр дундаа цар тахал, хөл хориотой холбоотой хот доторх автомашинаас эхлээд хил рүү түүхий эд ачдаг ачааны машинууд, нислэгүүд, галт тэрэг зэрэг бүхий л тээврийн салбарын хөдөлгөөнийг тодорхой хэмжээгээр хязгаарласан нь тээврийн салбарын 18.2%-ын бууралтын гол шалтгаан болсон бол мөн хөл хорины улмаас үйлчилгээний газрууд, дэлгүүр, захууд хаагдаж, хүмүүсийн худалдан авах чадвар буурсан нь худалдаа, үйлчилгээний салбарын бууралтад нөлөөлсөн байна.

2021 он гарснаас хойш 5 сарын дотор нийт 4 удаагийн хөл хорио тавигдсан. Гэвч уул уурхайн супер циклтай холбоотой зэсийн үнэ түүхэнд байгаагүйгээр өсөж, тонн тутамд 10'000 ам доллар хүрч, алтны үнэ ч улам өссөн. Мөн засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлснээр 2021 оны 2-р улиралд эдийн засгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 6.3%-ийн өсөлттэй гарахад дэмжлэг болсон. Гэсэн хэдий ч 2020 оны 2-р улиралд эдийн засаг 2019 оны мөн үеэс 9.0% буураад байсныг анхаарах хэрэгтэй. Учир нь үнэн хэрэгтээ бодит эдийн засаг 2011-2013 оны үетэй адил хурдацтай өссөн үү гэвэл үгүй. 2021 оны 2-р улирлын БДНБ-г 2019 оны 2-р улиралтай харьцуулахад 3.3%-ийн бууралт үзүүлсэн байгаагаас угтаа эдийн засаг цар тахал болохоос өмнөх төвшиндөө уул уурхайн супер цикл болон хөтөлбөрийн ачаар хүрсэн болох нь ажиглагдаж байна.



2

САНГИЙН
БОЛОН
МӨНГӨНИЙ
БОДЛОГО

САНГИЙН БОЛОН МӨНГӨНИЙ БОДЛОГО


Дэлхийн улс орнуудын нэгэн адилаар Монгол Улс цар тахалд нэрвэгдсэн эдийн засгийн сэргээхийн тулд мөнгөний зөөлөн болон сангийн тэлэх бодлогуудыг авч хэрэгжүүлсэн.

Мөнгөний бодлого



Эх сурвалж: Монголбанк

Сангийн бодлого



Эх сурвалж: УСХ


2020 онд эдийн засгийн өсөлт удааширч, ААНБ-ууд хөл хориотой холбоотой санхүүгийн хүнд байдалд орж эхэлсэн ба эдийн засгийн идэвхгүй байдлаас үүдэн инфляци 2020 онд 2.3% болж өмнөх оноос 2.9 пунктээр буурсан. Инфляци бага төвшинд хүрсэн энэ үед Монголбанкнаас бодлогын хүүг бууруулах шийдвэр гарч бодлогын хүү 4 удаа 1-2% -иар буурсан ба нийтдээ нэг жилийн дотор 5 пунктээр бууруулсан. Энэ нь зах зээл дээрх зээл болон хадгаламжийн хүүг бууруулж эдийн засгийн богино хугацаанд дэмжих арга байв. Мөн түүнчлэн Монголбанкнаас банкнуудын харилцах болон хугацаагүй хадгаламжийн дансны хүүг тэглэх, төлбөр тооцоо болон шилжүүлгийг гадны валютаар хийхийг хориглох, актив ангилах журмын нөхцөлийг өөрчлөх, зээлийн төлбөрийг хойшлуулах зэргээр хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь банкны салбарын зардлыг бууруулах, төгрөгийн үнэ цэнийг хадгалахад, иргэд ААНБ-уудын зээлийн дарамтыг бууруулах, утгаа мөн эдийн засгийн дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Эдгээр бодлогын зохицуулалт нь 2021 он дуустал үргэлжлэх хүлээлттэй байна. Нөгөө талаас Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй "Эдийн засгийг дэмжих 10 их наядын цогц хөтөлбөр" -ийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрт 3%-н хямд үнэ бүхий ААНБ-уудыг дэмжих зээл, иргэдийг дэмжих орон сууцны зээлүүд багтаж байв. Үүнээс гадна 2020 оноос эрчим хүч, хог хаягдал, усны төлбөрийн төр даах шийдвэрийг гаргаж 2021 он дуустал үргэлжлүүлэхээр хүлээгдэж байгаа бол 2021 оноос нийгмийн даатгалын шимтгэлийг багасгах арга хэмжээг авсан байна. Ингэснээр төсвийн орлого 2020 онд 12.8%-иар буурч, эсрэгээрээ төсвийн зардал 30.4%-иар өсөж, төсвийн алдагдал 5.5 их наяд төгрөг хүрсэн байна. 2021 онд эдгээр бодлогыг үргэлжлүүлэх шийдвэрийн дагуу төсвийн тодотгол хийж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.6 их наяд төгрөгийн алдагдалтай байх төсвийг баталсан.

Ийнхүү мөнгөний зөөлөн бодлого болон сангийн тэлэх бодлогыг хамтран хэрэгжүүлснээр мөнгөний нийлүүлэлт 2020 онд 16.3%-иар, 2021 оны 8-р сард 26.3% тус тус өссөн байна. Улмаар 2021 он гарснаар эдийн засаг идэвхжиж импортын барааны эрэлт өсөх, тээврийн хязгаарлалттай холбоотой тээврийн зардал өссөн зэрэг хүчин зүйлсийн үр дүнд инфляци 2021 оны 8-р сарын байдлаар 8.9%-д хүрсэн байна.

Засгийн газраас хэрэгжүүлсэн 2021 оны бас нэгэн онцлох үйл явдал нь "Зуун" бонд байв. Хуваарь ёсоор бид 2022 онд Чингис бондын 799.2 сая ам доллар, 2023 онд "Гэрэгэ" бондын 800 сая ам долларыг төлөх үүрэгтэй байсан. Тэгвэл долларын өгөөж буурсан, уул уурхайн супер циклтэй холбоотой түүхий эдийн үнэ өндөр байгаа энэхүү боломжийг ашиглан бага хүүтэй 6 болон 10 жилийн хугацаатай 1 тэрбум ам долларын бондыг амжилттай гаргаж, 2022, 2023 онд гарах валютын томоохон урсгалын дарамтыг бууруулсан.

ЗГ-ын бондын эргэн төлөлтийн хуваарь



3

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД



ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУД


УУЛ УУРХАЙ

Уул уурхайн салбарын өсөлт нь нийт ДНБ-ий өсөлтийг голчлон тодорхойлов.

Оюутолгойн 2021 оны 2-р улирлын үзүүлэлтэд зэсийн 83%-ийн үнийн өсөлт, алтны 136%-ийн үнийн өсөлт зэрэг нь уул уурхайн өсөлтийн гол түлхэц болсон. Гэсэн хэдий ч Оюутолгойд Ковид-19 вирус тархсаны улмаас төлөвлөгөөнөөс 25 хувиар бага үйлдвэрлэлээр ажилласан бөгөөд урт хугацааны саатал нь үйл ажиллагаанд нөлөөлсөн байна. Нөгөөтэйгүүр зэсийн агууламж өмнөх жилээс 51 хувиар буурчээ.


Нүүрсний экспортын 80 хувийг Гашуунсухайт, Шивээхүрэнгийн гарц эзэлдэг ч удаа дараа хил хаагдсанаас нүүрсний экспорт удаашрав. Улмаар хагас жилийн байдлаар нүүрсний гарц 2 дахин өсөөд байсан нүүрсний гарц тоо хэмжээгээрээ 10 хувь болж удааширч, зэсийн экспортын тоо хэмжээ жилийн өмнөхөөс 9 хувиар буураад байв. Хэдийгээр зэс болон нүүрсний гарц цар тахлын нөхцөл байдлаас үүдэн зогсонги байдалд орсон ч олон улсын эрэлтийг даваагүй нийлүүлэлтийн улмаас түүхий эдийн үнэ өссөнөөр манай улсын уул уурхайн сектор өсөхөд нөлөөлөв.

Уул уурхайн салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Уул уурхайн салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Уул уурхайн салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Олон улсад мөрдөж буй Парисын хэлэлцээр, Европын холбооны ногоон хэлэлцээр зэрэг нь нүүрсний үнийг 2050 он гэхэд аажмаар бууруулах төлөвтэй байна. Гэсэн ч БНХАУ-ын одоогийн эрчим хүчний үйлдвэрлэлийн дийлэнх хувийг эзэлж буй хатуу түлшний эрчим хүчний үйлдвэрлэлийг орлоход 40 орчим жилийн хугацаа шаардагдана гэж үзэж байна.

Зэсийн үйлдвэрлэл нь 2023 он гартал ийнхүү үнийн өсөлтийн төвшнөө барих төлөвтэй байгаа бөгөөд энэхүү олон улсын зэсийн үнийн өсөлт нь ногоон шилжилтийг удаашруулж болзошгүй байна. Олон улсад

цахилгаан машин, тоног төхөөрөмж рүү шилжихэд гол түүхий эд болох зэсийн үнэ нь эргээд энэхүү ногоон санхүүжилтийг улам үнэтэй болгож байгаа ч зэсийг голлон экспортолдог манай улсын гадаад худалдаанд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй юм.

Харин богино болон дунд хугацаандаа уул уурхайн салбарын өсөлт нь БНХАУ-ын олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлоготой шууд хамааралтай байгаа ба манай улсад Ковид 19-ийн тархалт нь эрс буурсан цагт уул уурхайн сектор бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжтой юм.

ХУДАЛДАА


Дэлхийн худалдааны нөхцөл 2008 оны санхүүгийн хямралаас хойш ихээхэн уналтад орж нийт эрэлт багасаж, нийт экспорт 10 хувиар буураад байв. Хэдийгээр энэхүү үзэгдэл нь сэргэсэн ч хөгжиж буй орнуудад хямд хөдөлмөрийн хүчний олдоц буурч, үүний зэрэгцээ БНХАУ болон АНУ-ын хоорондын худалдааны дайн нь олон улсын худалдааны өсөлтийг сааруулах болсон.

Ковид-19 вирусийн тархалт нь олон улсад нийлүүлэлтийн сүлжээний асуудлыг ил болгож улмаар хөдөлмөрийн хүч, нийлүүлэлтийн сүлжээний бүтцээ дахин хуваарилж, өөрчлөх явцыг хурдасгасан юм. Тээвэр ложистикийн хямрал нь олон улсад 2020 оны 2-р улиралд олон улсын худалдааны түүхэн доод төвшинд очоод байсан билээ.

Монгол Улсад худалдааны салбар нь уул уурхайг түшиглэн өсөж байна. Голчлон том оврын автомашин, тоног төхөөрөмж, түлш, суудлын автомашин (гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэд эрэлтийг өсгөв) гэх мэт уул уурхайн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн худалдаа нэмэгдэж, цахилгаан бараа, гэр ахуйн барааны худалдаа ч мөн адил нэмэгдэв. Түүнчлэн импортын тээврийн зардал өссөнтэй холбоотойгоор түүхий эд материалын үнэ өссөн байна.


Худалдааны салбарын зээл хөтөлбөрийн зээлээр эрс нэмэгдсэн.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Худалдааны салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Худалдааны салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Цаашдын чиг хандлага нь хилийн хязгаарлалт, Монгол Улс дахь цар тахлын тархалтын хэмжээ, Хятад улсын Ковид-19 бодлоготой шууд холбоотой юм. Дотоодын эрэлт нэмэгдэж байгаа цаг үед хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлэх үед өргөн хэрэглээний барааны худалдаа, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдаа огцом өсөх хандлагатай байна. Уул уурхайн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, түлшний эрэлт өндөр байна.

ҮЙЛЧИЛГЭЭ

Үйлчилгээний салбарууд эдийн засгийн гол цөмийг бүрдүүлдэг салбар билээ. Харилцаа холбоо, тээвэр, хоол хүнс, санхүү, эмнэлгийн үйлчилгээ, боловсрол, аж үйлдвэрт үзүүлэх техникийн үйлчилгээ зэрэг эдгээр салбар нь үндэсний орлогын 30 орчим хувийг, нийт ажиллах хүчний 25 хувийг бүрдүүлдэг юм.

Вакцинжуулалт нэмэгдэж, эдийн засгийг сэргээх санхүүгийн багц арга хэмжээ нь үйлчилгээний салбарт захиалга, борлуулалтын хэмжээг нэрлэсэн үнээр нэмэгдүүлэв. Хорио цээрийг аажмаар хөнгөвчлөхийн хэрээр голчлон нийтийн хоолны газар, ресторан, амралтын газруудын борлуулалт бага зэрэг өсөж, харин фитнесс, зочид буудал, амралтын газар, олон нийтийн шөнийн цэнгээний газруудын орлого эрс буурсан билээ.


Хөтөлбөрийн зээлийн нөлөөгөөр үйлчилгээний салбарын зээл үнэмлэхүй өссөн ч өндөр эрсдэлтэй учраас зээлийн өсөлт удааширч байна.

Үйлчилгээний салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Үйлчилгээний салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Үйлчилгээний салбарын зээлийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Дотоодын аялал жуулчлал нэмэгдэхийн хэрээр жуулчлалын чиг хандлага нэмэгдэх байна. Гэсэн хэдий ч гадаад улсуудын хилийн хязгаарлалт, дельта хувилбарын тархалт зэргээс шалтгаалан үйлчилгээний салбар 2022 оны хоёрдугаар хагаст 2019 оны энгийн төвшинд өсөх төлөв ажиглагдахгүй байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ


Үйлдвэрлэлийн салбар нь 2017-2018 онд уул уурхайн өсөлтийг даган 20 хувийн өсөлттэй байсан салбар юм. Цар тахлын эхний жилд өсөлт саарч, оны эцэст 1 хувиар өссөн бөгөөд үүний дараагаар үйлдвэрлэгчдийн сегмент бүрийн сэргэлт харилцан адилгүй байна. Цар тахал нь нэгээс олон улсыг хамарсан нийлүүлэлтийн сүлжээний сул талыг ил болгож, тээвэр ложистик, мөнгөн урсгалын дутагдлаас үүдэн хүнсний бус үйлдвэрлэлд ихээхэн хохирол амсуулав. 2020 он цар тахлын эхэн үед хөл хорио тавьж, үйлдвэрлэлийн захиалга буурах, нөгөө талаас нийлүүлэлтийн сүлжээний асуудалтай холбоотойгоор үйлдвэрлэлийн салбарын ажил эрхлэлтийн төвшин мэдэгдэхүйц буурсан бөгөөд 3-р сард 2013 оноос хойш үйлдвэрлэлийн хамгийн бага ажил эрхлэлтийн төвшин бүртгэгдсэн юм.

Үйлдвэрлэлийн салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Үйлдвэрлэлийн салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Үйлдвэрлэлийн салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Хүнсний салбар нь үйлдвэрлэлийн салбарын тал хувийг эзэлдэг ба Ковид-19-ийн улмаас иргэд гэртээ байхыг илүүд үздэг болсон тул хүнсний үйлдвэрлэл, эмийн үйлдвэрлэл нэмэгдэж 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт үйлдвэрлэл 13 хувиар, нийт борлуулалт 27 хувиар өссөн байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд хэрэглэгчийн худалдан авах зуршилд олон өөрчлөлт орсон бөгөөд энэхүү шилжилт нь энгийн үед маш олон жил шаарддаг билээ. Үйлдвэрлэлийн секторт хүнсний онлайн дэлгүүрийн худалдан авалт хурдацтай явагдаж, түгээлт, үйлдвэрлэлийг өөрчлөн хэлбэржүүлэх шаардлагыг бий болгож байна. Цаашид үйлдвэрлэлийн салбарын өсөлт нь дотоодын эрэлт нэмэгдэхийн хэрээр өсөх бөгөөд хүнсний сектор, мөн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч секторууд бодлогын зохицуулалтаар өргөжих хандлагатай байна.

БАРИЛГА


Хорио цээрийн дэглэмийн улмаас барилгын салбарын үйл ажиллагаа удааширснаар 2020 онд нийт 37,000 гаруй орон сууц хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байсан боловч оны эцэс гэхэд 42%-иар буюу 15,400 айлын орон сууцыг хүлээлгэн өгч, 58% нь 2021 он хүртэл шинээр ашиглалтад орох орон сууцнууд хойшилжээ.

Монгол Улсруу гадаад улсаас буцаж ирсэн иргэд шинэ орон сууцны эрэлтийг нэмэгдүүлэх, тээврийн үнийн өсөлтөөс үүдсэн бараа материалын үнийн 20-50 хувийн өсөлт, байршил, зэрэглэлийн хувьд орон сууцны үнийн өсөлт, орон сууцны хөнгөлөлттэй зээл, тодорхой бус байдал, дотоод шилжилт хөдөлгөөн зэрэг олон үйл явдал нь шинэ орон сууцны үнийг 8.8 хувиар нэмэгдүүлж, дундаж метр квадрат тутамд 2.6 сая төгрөгт хүргэжээ.

Ипотекийн зээл олголт нь зөвхөн орон сууцны барилгын санхүүжилтийг хангаж байгаа бөгөөд барилгын материалын үйлдвэрлэлд мөнгөн урсгалын дутмаг байдлаас үүдэн бартераар үйл ажиллагаагаа хэвийн явуулах гэсэн оролдлогууд нь эргээд орон сууцны өртөг өсөхөд ч мөн нөлөөлж байна. Барилгын түүхий эдийн үнийн өсөлт, институцийн мөнгөн урсгал байхгүйгээс барилгын үйл ажиллагаа ийнхүү удааширч байна. Барилгын салбарын борлуулалт 23 хувиар буурч, нийт үйлдвэрлэл эхний хагасын байдлаар 40%-иар буурав.


Ийнхүү эрсдэлтэй барилгын салбарын зээл төдийлөн сайжралгүй, буурсаар байна.

Барилгын салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Барилгын салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Барилгын салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Цаашдын чиг хандлага нь хилийн хязгаарлалт, Хятадын Ковид-19 бодлоготой шууд холбоотой юм. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал ирэх онд өсөх төлөвтэй байна. Төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан Засгийн газраас шинээр барьж буй барилгын ажил өмнөх жилүүдээс буурах магадлалтай байв. Гэсэн хэдий ч эдийн засгийг эрчимжүүлэх шинэ бодлого ирэх онд орон сууцны бус барилга байгууламжийг нэмэгдүүлэх боломжтой юм. Харин тодорхой бус байдал, хөнгөлөлттэй орон сууцны зээл зэрэг нь эрэлтийг ихээхэн нэмэгдүүлж байгаа ба тус эрэлтийг хязгаарлагдмал, өртөг ихтэй түүхий эдээр хангах оролдлого нь орон сууцны үнийг богино хугацаандаа эргэн буурахгүй байхыг харуулж байна.

ТЭЭВЭР

Тээврийн салбар нь өнөөгийн эдийн засаг, нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд өсөлт, ажил эрхлэлтэд ихээхэн нөлөөлдөг. Монголын тээврийн салбарт 70 мянга орчим хүн ажилладаг бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 4.5 орчим хувийг бүрдүүлдэг. Тээврийн систем нь Монгол Улсын компаниудын дэлхийн эдийн засагт өрсөлдөх чадварыг бий болгох үндэс суурь болдог.

Харин 2021 он гарснаар дэлхийн ложистикийн хямрал үүсэж "Дэлхийн үйлдвэр" гэж нэрлэдэг БНХАУ дахь үйлдвэр, дэлгүүр, дотоод тээврийн систем, олон улсын боомтуудыг хааснаар Монгол улсад төдийгүй тус улстай худалдаа эрхэлдэг бүхий л улс оронд нийлүүлэлтийн сүлжээний хямрал үүсээд байгаа билээ. БНХАУ-ын Ковид-19 вирусийн тархалтыг зогсоох хүчин чармайлт нь үргэлжилж Гашуунсухайт, Шивээхүрэн, Эрээн хотын хилүүд бизнесийн улирлын ихэнх хугацаанд хаагдав. Улмаар Монгол Улсын тээврийн салбарт ажиллах ажиллагсдын тоо 50 мянга орчим болж буурч, ажилгүйдэл ихсэж, хилээр нэвтрэх ачаа тээшийн үнэ нэмэгдсэн ч тоо хэмжээгээр 10 дахин буурсан юм. Үүнээс үүдэн тээврийн салбарын өсөлт үнэмлэхүй удааширч, 2020 оны 33 хувийн бууралтаас 2021 оны эхний хагасын байдлаар 2 хувиар л өсөв. Орон даяар авто зам, төмөр замын ачаа тээвэрлэлт үргэлжилж байгаа ч агаарын тээврийн өсөлт буурч, 17 хувиар буурсан юм.


Тээврийн салбар нь цар тахал гарахаас өмнө ч хөгжлийн хувьд асуудалтай байсан салбар юм. Цар тахал нь салбарын бүрэн шийдэж чадаагүй үндсэн үр ашиггүй байдлыг ил болгоход ердөө хэдхэн сар л зарцуулав. ААНБ-үүдэд мөнгөн урсгалын тулгамдсан асуудлууд, олон жилийн турш бий болсон салбарын асуудлуудыг даван туулах шаардлагыг бий болгов. Тус салбарын зээл энэ оны эхний хагасын байдлаар 41 хувиар өссөн байна. Энэ нь голчлон уул уурхайн салбарын өсөлтийг дагасан үзүүлэлт юм.

Тээврийн салбарын борлуулалтын орлогын өсөлт




Эх сурвалж: YCX

Тээврийн салбарын БДНБ-ны өсөлт



Эх сурвалж: YCX

Тээврийн салбарын зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Цаашдын чиг хандлага нь хилийн хязгаарлалт, Хятадын олон нийтийн эрүүл мэндийн бодлоготой шууд холбоотой байна. Цар тахлын тархалт намжихын хэрээр уул уурхайн салбартай зэрэгцэн огцом нэмэгдэх төлөвтэй байна. Нөгөөтэйгүүр, 2022 оны төсвийн төсөлд хөрөнгийн зардлыг өмнөх жилээс 2 дахин нэмэх төлөвтэй байгаа ба тус төлөвлөгөөнд авто замын хөгжил, дэд бүтцэд түлхүү хөрөнгө оруулах төлөвтэй байгааг онцлууштай. Тус шийдвэрүүд нь уул уурхайн түүхий эдийн үнийн өсөлттэй зэрэгцэн тээврийн салбарын өсөлтийг хурдасгах төлөвтэй байна.



4

ИРЭЭДҮЙН
ХҮЛЭЭЛТ

ИРЭЭДҮЙН ХҮЛЭЭЛТ

Олон улсад цар тахлын нөхцөл байдал гарч эхэлсэн үеэс эхлэн манай улсад төдийгүй олон улсад тодорхой бус байдлыг бий болгож эрүүл мэндийн бодлого, төрийн зохицуулалт, гадаад худалдаа, олон улсын нийлүүлэлтийн сүлжээ болон санхүүгийн салбарт ихээхэн эрсдэлүүдийг дагуулсан. Түүнчлэн тус вирусийн хамгийн хурдацтай тархалттай дельта вариант эдийн засгийн сэргэлтийг удаашруулж буй. Гэсэн хэдий ч олон улсад ногоон хөгжлийн чиглэлд явагдаж буй зэс болон гангийн үйлдвэрлэл БНХАУ-ын аж үйлдвэржилтийн чиглэлд явагдаж буй хурдацтай сэргэлт зэрэг нь Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлд эерэгээр нөлөөлж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Уул уурхайн түүхий эдийн экспорт нь манай улсын нийт экспортын 90 хувийг эзэлдэг төдийгүй түүхий эдийн үнийн байдал макро эдийн засгийн үйл явдлын 30 хувийг эзэлдэг. Хятадын эдийн засгийн сэргэлтэд түшиглэсэн түүхий эдийн эрэлт өндөр байгаа тул түүхий эдийн үнэ тогтвортой байх төлөвтэй байна. Нөгөөтэйгүүр, ойрын хэдэн жилийн хугацаанд уул уурхайн томоохон шинэ төслүүд, өргөтгөлүүд ашиглалтад орох төлөвтэй байгаа тул олон улсад үйлдвэржилт нэмэгдэх хандлагатай байна.


НҮҮРС

2019-2024 оны хооронд дэлхийн сэргээгдэх эрчим хүчний тэлэлтийн 40 хувийг БНХАУ бүрдүүлэх бөгөөд үүнд системийн интеграцчлал сайжирч, машины хэмжээ буурч, нарны гэрэл болон хуурай газрын салхины эрчим хүчний өрсөлдөх чадвар сайжирна гэж үзэж байна. Энэ хугацаанд Хятад улс дэлхийн фотовольтаикийн өсөлтийн бараг тэн хагасыг бүрдүүлэх төлөвтэй байгаа бөгөөд 2021 он гэхэд Европын холбоог гүйцэж, суурилагдсан хүчин чадлаараа дэлхийд тэргүүлэх болно.

Гэсэн хэдий ч Хятадын нүүрсний хэрэгцээ, үйлдвэрлэлийн хүчин чадал өндөр хэвээр байгаа бөгөөд одоогийн байдлаар дэлхий даяар нийт 4 тонн нүүрс тутмын нэгийг Хятадад цахилгаан үйлдвэрлэхэд зарцуулж байна. Засгийн газар аж үйлдвэр, орон сууцны салбарт хийн түлш рүү шилжих замаар утааг бууруулах, агаарын чанарыг сайжруулахыг шаардаж байгаа боловч Хятадын нүүрсний үйлдвэрлэл өндөр үр ашигтай, хийн түлшний флотоос нь 10 дахин том хэвээр байна. Энэ нь ирэх 5 жилд Монгол Улсын коксжих нүүрсний үнийг өндөрт хадгалж, эрэлт тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлж байна.

24

Нүүрсний үнийн таамаглал




Эх сурвалж:
- ОУВС
- Блүүмберг терминал

¹ Фотовольтаик гэдэг нэр томъёо нь гэрлийн энергийг шууд хувиргагчийг хэлэх ба ихэнхдээ нарны гэрлийг фото элементийн тусламжтайгаар цахилгаан энерги болгон хувиргана. (Wikipedia, 2021).

ЗЭС

Дэлхийн зэсийн уурхайн үйлдвэрлэл 2021 оноос эхлэн өргөжин, зэсийн үнэ, эрэлтийн өсөлтийг дэмжсэн шинэ төслийн өргөтгөлүүдийн тоо нэмэгдэх тул ирэх онуудад гарц нь өндөр байх төлөвтэй байна. Дэлхийн зэсийн уурхайн үйлдвэрлэл 2021-2030 онуудад жилд дунджаар 3.7% -иар өсөж, 2020 онд 20.2 сая тонн байсан бол арван жилийн эцэс гэхэд 29.4 сая тонн болж өснө гэж Fitch rating дурджээ. Зэсийн үнийн өсөлтийн гол хөшүүрэг нь ногоон эдийн засгийн хөгжлийн чиглэлд цахилгаан авто машины үйлдвэрлэл юм. Цахилгаан автомашины үйлдвэрлэл энэ онд нийт машин үйлдвэрлэлийн 5 хувийг эзэлж буй бөгөөд ирэх 5 жилийн хугацаанд энэ тоо 3 дахин өсөх төлөвтэй байна. Цахилгаан автомашины үйлдвэрлэлд зэсийн хэмжээ түлшний хэрэглээтэй автомашинаас 4 дахин их зэсийн агууламжтай байдаг нь ийнхүү олон улсад зэсийн эрэлтийг нэмэгдүүлж байна.

Зэсийн үнийн таамаглал



Эх сурвалж:
- ОУВС
- Блүүмберг терминал

САНГИЙН БОЛОН МӨНГӨНИЙ БОДЛОГО

Төв банк бизнес эрхлэгчдийг тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, цар тахлын үед хувийн хэрэглээг тогтвортой байлгахын тулд 2020 онд бодлогын хүүгээ 5 нэгж хувиар бууруулсан. Энэ онд хэрэглээний үнийн өсөлт дунджаар 7.0 хувь байх таамаглалтай байна. Учир нь хэдийгээр тээвэр, түлшний үнэ болон махны үнийн өсөлттэй холбоотой нийлүүлэлтийн хүчин зүйл бүхий инфляц 8-р сарын байдлаар 8.9 хувьд хүрсэн ч оны эцэс хүртэл эдгээр үнэ буурах боломжтой. Одоо үүссэн байгаа инфляци нь нийлүүлэлтийн гаралтай тул эрэлтийн инфляцын хэрэгсэл болох бодлогын хүүгээр бууруулах боломжгүй тул энэ онд Монголбанк бодлогын хүүг 6 хувь дээр барина гэсэн хүлээлттэй байна. Харин 2022 оноос инфляц өсөж, үндэсний мөнгөн тэмдэгтийн өгөөж буурах эрсдэлээс болгоомжлон бодлогын хүүг өсгөх замаар мөнгөний бодлогыг чангатгана. Эдийн засагт цар тахлын тархалтын шууд нөлөө буурах 2023-2026 онуудад өрхийн орлого өсөж, дотоодод эрэлт нэмэгдэн, хэрэглээний үнэ өсөх ч гадаад худалдааны нөхцөл сайжирч төгрөгийн өгөөж тогтвортой хадгалагдах нөхцөлийг авч үзэн бодлогын хүүг 6-7 хувьд хадгалагдана гэж үзэж байна.

Инфляц

Хилийн хязгаарлалт, газрын тосны үнийн өсөлт нь тээврийн зардлыг нэмэгдүүлж, инфляцыг үнэмлэхүй өсгөж байна. Аж ахуйн нэгжүүд үүд хаалгаа нээж, эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр эрэлтээр өдөөгдсөн инфляц нэмэгдэх магадлалтай. 2021 оны эцсээр инфляц 7.0 хувь хүрэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч импортын барааны дотоодын эрэлт нэмэгдэхийн зэрэгцээ бодлогын хүүг бууруулсан зэрэг шалтгаанаас инфляцын төвшин 2022 оноос эхлэн өсөх магадлалтай байна. Голлох түүхий эдийн өсөлтөөс үүдэн зээлжих зэрэглэл нэмэгдсэнээс улсын гадаад өрийг амжилттай дахин санхүүжүүлж, гадаад худалдааны таатай нөхцөл зэрэг нь 2026 хүртэлх жилүүдэд төв банк инфляцыг 6 орчим хувьд барих зорилтдоо

хүрэх нөхцөлийг бүрдүүлнэ. Эдийн засгийн идэвхжил, цалин хөлс нэмэгдэхийн хэрээр импортын эрэлт огцом нэмэгдэх болно. Тус таамаглал биелэхэд учирч болзошгүй эрсдэлд олон улс даяар эдийн засаг хурдан сэргэж, зах зээл дээрх газрын тосны үнийг өсгөж, тээврийн зардлыг улам бүр нэмэгдүүлэх магадлалтай. Эдгээр нь эцсийн дүндээ инфляцыг 8 хувийн зорилтот төвшнөөс өсгөж болзошгүй юм.

Ханш

Өргөн хэрэглээний барааны үнэ, экспортын ачаар гадаад худалдааны тэнцэл оны эхнээс эерэг байв. Засгийн газрын бонд гаргасан нь гадаад валютын гадагшлах урсгалыг хойшлуулсан. Монголбанкны 500 сая ам.долларын интервенц, импортын барааны дотоод эрэлт нь төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг хангах шалтгаан болно. Энэ нь ойрын жилүүдэд ханш тогтвортой байх төлөвтэй байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч Хятад улс хилээ хаахад экспортын өсөлт саарах эрсдэл байгааг анхаарах шаардлагатай. Засгийн газар “Гэрэгэ”, “Хуралдай” бондуудын үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжүүлэх боломжгүй болсон тохиолдолд валютын ханш огцом өсөх эрсдэлтэй байна. Суурь таамаглалд бид ОюуТолгойн далд уурхай, Тавантолгойн төмөр зам, дотоодод газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг арга хэмжээний зэрэгцээ гадаад өрийн эргэн төлөлтийг амжилттай биелүүлснээр 2026 он хүртэлх валютын гадагшлах томоохон урсгалыг дарж, ханшийн дарамтыг бууруулна хэмээн үзэж байна.

Цар тахалд нэрвэгдсэн эдийн засгийг сэргээж, өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэглээг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн тусламжийн арга хэмжээ нь улсын нэгдсэн төсвийг 2020 онд 4.5 их наядын алдагдалтай гаргахад хүргэв. Засгийн газраас цар тахлын эсрэг цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдэд шаардагдах зардлыг 2021 оны төсөвт тусгаснаар төсвийн алдагдлын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 8.8 хувь буюу 3.5 их наяд төгрөг хүрч нэмэгдэхээр байна. Ийнхүү сангийн алдагдал, гадаад өрийн эргэн төлөлтийн хугацаа ойртсон энэ үеүдэд Монгол Улсын Засгийн газар гадаад улс орнууд болон олон улсын байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл татахын зэрэгцээ 6 ба 10 жилийн хугацаатай, 1 тэрбум ам.долларын бонд гаргасан нь ирэх жилүүдийн гадаад өрийн дарамтыг бууруулсан билээ. Засгийн газар цаашид Гэрэгэ болон 2024 оны Хуралдай бондын эргэн төлөлтийн үлдэгдлийг дахин санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргаж, улмаар цаашдын гадаад өрийн дахин санхүүжилтийг амжилттай гүйцэтгэнэ хэмээн үзэж байна. 2026 он хүртэл түүхий эдийн супер циклээс үүдэн сайжрах төлөвтэй манай улсын зээлжих зэрэглэл нь ирээдүйн гадаад өрийн санхүүжилт болон Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцлийг амжилттайгаар хойшлуулах бололцоогоор хангаж байна.

МЕГА ТӨСЛҮҮД

Монгол Улсын нийт экспортын 25-30 хувийг бүрдүүлдэг зэсийн экспортын гол нийлүүлэгч Оюутолгой компанийн далд уурхайн үйл ажиллагаа 2022 оны 10 -аар сард төслийн үйлдвэрлэлээ эхлүүлэх төлөвтэй байна. Уурхайд 5.3 тэрбум долларын гүний бүтээн байгуулалтын ажил төлөвлөгөөний дагуу үргэлжилж, батлагдсан нөөц нь 355 сая тонн, уурхайн амьдрал 31 жил байх тооцоололтой байна. ОТ далд уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхэлснээр 2023 оноос эхлэн зэсийн экспорт үнэмлэхүй нэмэгдэж, тахлын тархалт буурах ба экспорт өргөжиж, эдийн засаг илүү хурдацтай сэргэнэ. Уул уурхайн супер мөчлөгийн үеэр экспорт 2025 он хүртэл тогтвортой байна хэмээн үзэж байна.

Түүнчлэн Тавантолгойн нүүрсийг Гашуунсухайт болон Зүүнбаянгийн төмөр замын төсөл 2022 онд дуусгахаар төлөвлөж байгаа хэдий ч хорио цээрийн дэглэмээс ихээхэн хамаарна. Хоёр хилээр төмөр зам амжилттай барьснаар нүүрсний экспортыг одоогийн хэмжээнээс дор хаяж хоёр дахин нэмэгдүүлэх болно. Суурь таамгийн хувьд цар тахлын улмаас хилийн хязгаарлалт, барилгын материалын үнэ нэмэгдэх нь төслийг хойшлуулахад хүргэж болзошгүй.


Энэтхэгийн хөрөнгө оруулалтаар Засгийн газар 2024 онд 1.5 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэрийг хөнгөлөлттэй зээлийн хүрээнд барихаар төлөвлөж байгаа бөгөөд нийт нефтийн импортын 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг дотооддоо нийлүүлэх төлөвтэй байна. Тус үйлдвэр нь Монгол Улсын импортын бүтээгдэхүүний нийт хэмжээг 700 сая гаруй ам.доллараар бууруулах төлөвтэй байгаа ба 2024 оноос эхлэн гадаад валютын гадагшлах урсгалыг ихээхэн хэмжээгээр бууруулах тооцоололтой байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Цар тахлын дараах үеийн сэргэлт удаан, тогтворгүй байх магадлалтай байна. Эрх баригчид цар тахлыг хяналтдаа авч, дотоодын эрэлтийг өдөөж, дэлхийн эдийн засгийн сөрөг нөлөө буурч, бизнес эрхлэгчид болон иргэд Ковид-19 өвчинтэй дасан зохицож, вакцинжуулалт эрчимтэй хийгдэж улмаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх иргэдийн хувь буурснаар ДНБ-ий өсөлт 2021 онд 5 хувиар өснө хэмээн үзэж байна. Гэвч дараах хүчин зүйлс эрсдэл дагуулж болзошгүй юм. Үүнд:

1. Дотоодын Ковид-19 тохиолдлын тоо огцом нэмэгдэж, хатуу хөл хорио, удаан хугацаагаар үргэлжлэхэд хүргэж болзошгүй юм.
2. Вирус цаашид төрөлжиж, олон улсад болон дотоодод тархалтын давлагаа үүсэх магадлал.
3. Бодлогын зохицуулалтууд хязгаараас давж, банкны салбарын балансын бүтэц алдагдсанаар санхүүгийн салбарт тогтворгүй байдал үүсэж болзошгүй.
4. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой цочрол (жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарт нөлөөлж болзошгүй хатуу өвөл, халуун зун).

Бодит ДНБ-ны өсөлтийн таамаглал



Олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсыг 5-6 хувьд өснө хэмээн үзэж байна. Үүнд Дэлхийн банк 5.9 хувь, EIU 4.9 хувь, Азийн хөгжлийн банк 5 хувиар өсөх төлөвтэй гэж үзэж байна. Энэхүү өсөлтийн дийлэнхийг уул уурхай, тээврийн салбар бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, өсөлтийн гол шалтгаан нь түүхий эдийн үнэ (зэс, нүүрс, алт) өссөнтэй холбоотой байх болно гэж тус байгууллагуудаас үзэж байна. Түүнчлэн цар тахлын эсрэг арга хэмжээг 2021 он дуустал хэрэгжүүлэх төлөвтэй байна. 2022 оноос эхлэн дэлхийн чиг хандлага аж үйлдвэржилт, ялангуяа цэвэр эрчим хүч рүү шилжихийн хэрээр олон улсын хөгжиж буй зах зээлийн өсөлтийг хурдасгах магадлалтай байна. Гангийн болон цахилгаан автомашины үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах томоохон үйл ажиллагаа нь түүхий эдийн засгийг бэхжүүлэх магадлалтай. Аялал жуулчлал, үйлчилгээний салбаруудын Ковид-19-ийн дараах үеийн

сэргэлтийг харгалзан үзвэл 2022 онд Монголын эдийн засагт уул уурхай, тээврийн салбар тэргүүлж, 6.7 хувь, 2023 онд 6.9 хувиар өснө гэж бид үзэж байна. Харин Оюутолгойн далд уурхай, Тавантолгойн төмөр зам зэрэг төслүүд энэ өсөлтийн гол хөшүүрэг болж байна. 2024 оноос эхлэн гадаад худалдааны үйлдвэрлэл хурдацтай хөгжихийн хэрээр хүчтэй өсөлт үргэлжлэх боловч 2025, 2026 оноос өсөлтийн хурд саарах авч 5 хувь байх хүлээлттэй байна.

Үзүүлэлт	Нэгж	Гүйцэтгэл			Таамаглал	
		2019	2020	2021 Aug	2021*	2022*
Бодит эдийн засаг						
Бодит ДНБ-ний өсөлт (жилийн) *	%	5.6%	-4.6%	6.3%	4.5%	5.2%
Хөдөө аж ахуй	%	5.2%	5.8%	-4.6%	-3.9%	4.0%
Уул уурхай	%	-1.6%	-9.9%	24.3%	14.8%	13.3%
Худалдаа	%	10.9%	-12.5%	7.8%	11.9%	8.8%
Үйлчилгээ	%	5.1%	-2.0%	1.6%	2.8%	2.2%
Үйлдвэрлэл	%	3.8%	3.4%	12.7%	4.2%	2.0%
Барилга	%	20.3%	-3.2%	-39.7%	2.7%	0.5%
Тээвэр	%	4.4%	-18.2%	2.5%	3.2%	1.0%
Мөнгөний зах						
Инфляци	%	5.2%	2.3%	8.9%	7.0%	7.5%
Мөнгөний нийлүүлэлт	их наяд ₮	20.8	24.2	27.1	29.5	32.4
Жилийн өсөлт	%	7.0%	16.3%	26.3%	21.8%	9.9%
Бодлогын хүү	%	11.0%	6.0%	6.0%	6.0%	7.0%
Ам долларын ханш **	₮/\$	2,734.3	2,849.9	2,849.5	2,853.0	2,901.5
Түүхий эдийн зах зээлийн үнэ						
Нүүрс	\$/тонн	70.5	80.6	173.6	167.3	95.4
Зэс	\$/тонн	6,077.1	7,772.2	9,370.1	9,140.0	9,092.5
Алт	\$/трой унц	1,476.0	1,856.0	1,784.0	1,758.0	1,677.3
Төмрийн хүдэр	\$/тонн	91.0	153.1	162.1	119.3	100.0
Газрын тос	\$/баррель	65.9	49.9	70.0	74.5	68.7

Тайлбар:
 * - БДНБ-г тооцохдоо 2015 оны суурийг ашигласан ба 2010 он суурь бүхий БДНБ-с тооцсон өсөлтөөс ялгаатай болно.
 ** - Сарын/жилийн сүүлийн өдрийн ханш

Эх сурвалж:
 - УСХ
 - Монголбанк
 - ОУВС
 - Блүүмберг терминал
 - Эдийн засгийн судалгааны алба, Голомт банк



5

БИЗНЕС ДЭХ
КОВИДЫН
НӨЛӨӨЛӨЛ
СУДАЛГАА

“АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН БИЗНЕС ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ КОРОНАВИРУСЫН НӨЛӨӨЛӨЛ 2021” СУДАЛГАА

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

- 2020 онд коронавирусын нөлөө эдийн засагт илүү хүчтэй байсан бол 2021 оноос эхлэн бизнесийн үйл ажиллагаа хэвийн байдалд шилжиж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад коронавирусээс үүдсэн айдас, хүлээлт арилж, дасан зохицож эхэлснээс гадна Засгийн газрын мөнгөний тэлэх бодлого нь компаниудад сэргэлт авчирсан байна. Гэсэн ч 2021 оны хагас жилийн үзүүлэлтүүд нь өмнөх оны хүлээлтээс доогуур байгаа юм.
 - Хүлээлт: 2020 оны сүүлээр вакцины мэдээллийн нөлөөгөөр аж ахуйн нэгж байгууллагууд (ААНБ) нэлээд эерэг хүлээлттэй байсан боловч 2021 онд мутацлагдсан вирус гарснаар вакцины нөлөө төдийлөн сайн үр дүнд хүрч чадаагүй. Энэ нь 2021 хагас жилийн байдлаар компаниудын борлуулалт, цэвэр ашгийн өсөлт хүлээлтээс доогуур гарахад нөлөөлж байна. Борлуулалтын орлого томоохон ААНБ-уудын хувьд дунджаар 7 хувийн өсөлт үзүүлнэ гэсэн таамаг байна. Харин өмнөх оны сүүлээр 2021 оныг 12 хувийн өсөлт үзүүлнэ гэж таамаглаж байсан юм.
 - Системийн зээлийн өсөлт¹: Банкны системийн хувьд засгийн газраас ААНБ-уудыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн “Ажлын байрыг дэмжих зээл”, Репо санхүүжилтийн зээлүүд нь системийн хэмжээнд зээл олголтыг 10% нэмэгдүүлсэн байна. Үүнээс хамгийн өндөр олголт хийсэн салбарууд нь тээвэр 41%, ХАА 27%, худалдаа 25%, үл хөдлөх 26% олголт хийсэн.
- ААНБ-уудын орлого, үр дүнгийн үзүүлэлт дэх нөлөөг авч үзэхэд үйлчилгээний салбарын борлуулалтын орлого, үйл ажиллагааны зардалд хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Бусад салбарын хувьд цэвэр ашгийн хувь харьцангуй эерэг гарах хүлээлттэй байгаа ба тэр дундаа үйлдвэрлэл, уул уурхай, эрүүл мэндийн салбарууд өндөр өсөлттэй байх хүлээлттэй байна.
- Иргэдийн орлого: Иргэдийн сегментийн хувьд дундаж цалин 2020 онд 21%-иар, 2021 оны хагас жилийн байдлаар 5%-р өссөн байна. 2020 оны өсөлт нь 2 үндсэн шалтгаантай: 1. 2020 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлж 420,000 төгрөг болгосон, 2. Эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний хүрээнд 2020 оны 4 сарын 1-ээс 10 сарын 1 хүртэл ХАОАТ, НДШ-ийг чөлөөлсөнтэй холбоотой өсөлт юм.
- Иргэдийн хэрэглээ: Ковидын нөхцөл байдал нь иргэдийн хэрэглээний хандлагад өөрчлөлт оруулж байгаа бөгөөд үйлчилгээний салбарын хэрэглээ буурч, худалдааны салбарын хэрэглээ өсөхөд нөлөөлсөн байна. Жишээлбэл, гоо сайхны үйлчилгээний орлого 10%-иар буурсан бол гоо сайхны худалдааны орлого 52%-иар өсжээ.
- Каринтины нөлөө: Каринтины эхний үе буюу 2020.02-03 сард нийт 45 салбарын 31% нь хөл хорионы нөлөөнд өртсөн бол 2 дахь үе буюу 2020.11-2021.04 сард 80% нь өртсөн байна.

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2019 оны сүүлээр коронавирус БНХАУ-ын Ухан мужид тархаж эхэлснээс нийгэм, эдийн засагт дэлхий даяар тодорхойгүй нөхцөл байдал үүсч 2020 оны эх гэхэд БНХАУ-аас гадна бусад олон оронд халдвар бүртгэгдэж эхэлсэн юм. Энэ үед Монгол Улс ч халдварыг дотооддоо алдахгүй байх зорилгоор зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь бизнесийн идэвхжил болон иргэд ААНБ-уудын орлогыг бууруулсан нь ковидын халдварыг дотоодод алдаагүйн алдагдсан боломжийн өртөг болсон юм.

Ийнхүү 2020 оны 11 сар хүртэл дотоодод халдвар бүртгэгдээгүй ч эдийн засгийн өсөлт -4.6² хувиар буурсан бол 2021 оны хагас жилийн байдлаар 6.3 хувиар өссөн байна.

Энэхүү судалгааг корпорэйт, жижиг дунд, иргэд гэсэн 3 сегментийн хүрээнд магадлалт бус түүврээр асуумжийн аргаар хийсэн болно.

¹ Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл, Монголбанк


² Үндэсний тооцооны статистик, УСХ

Судалгааны түүвэр

Судалгааны эх олонлог нь Голомт банкны нийт харилцагч байгууллагууд юм. Сегментээр нь корпорэйт болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч ААНБ-ууд гэж ангилсан. Түүврийг бүрдүүлэхдээ банкны нийт харилцагчдийн зээл, эх үүсвэр, болон эдийн засгийн үйл ажиллагааны харьцаанууд дээр үндэслэн оновчтой түүврийн хэмжээг тодорхойлж, магадлалт бус түүврийн аргаар асуулгуудыг цуглуулсан болно.

Судалгааны түүврийн салбараар болон сегментээр ангилсныг хавсралтаар оруулав.

Түүврийн бүтэц, салбараар



Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй нийт аж ахуйн нэгжүүд болон судалгаанд хамрагдсан нийт ААНБ-уудын эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын тархалтаар нь харахад улсын дүнг төлөөлж чадахуйц пропорцоор түүвэрлэсэн болно.

Салбарын ангилал

Үндэсний статистикийн хорооны ашиглаж буй эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллыг ашигласан бөгөөд зарим нэгтгэлийг хийснийг дэлгэрэнгүй байдлаар хавсралт №2-т оруулав.

Дундаж ажилчдын тоо



Судалгаанд хамрагдсан корпорэйт ААНБ-ууд нь 2021 онд дунджаар 291 ажилтантай, жилд дунджаар 44.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой бол жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид дунджаар 78.6 ажилтантай, жилд дунджаар 2.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байна.

Дундаж борлуулалтын орлого




БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ НӨЛӨӨ

Үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал

2020 оны 5 сарын байдлаар судалгаанд оролцсон байгууллагуудын 9% нь бүрэн зогссон, 45% нь хэсэгчлэн зогссон байдалтай байсан бол 2021 оны хагас жилийн байдлаар үйл ажиллагаа бүрэн зогссон ААНБ-уудын эзлэх хувь 5 нэгж хувиар өсөж 14%-д хүрсэн. Харин хэсэгчлэн зогссон ААНБ-уудын эзлэх хувь 45-41% болж буурсан. Өөрөөр хэлбэл, 2021 оны эхний хагас жилийн байдлаар ковидоос шалтгаалан үйл ажиллагаа доголдсон компаниудын тоо нэмэгдсээр байна.

Үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал




Салбаруудын тайлбар

Корпорэйт сегментийн хувьд 6.9% нь бүрэн зогссон, 41% нь хэсэгчлэн зогссон, 52% нь үйл ажиллагаанд ковид нөлөөлөөгүй буюу хэвийн байна.


Сегмент болон салбараар задлан харвал корпорэйт байгууллагуудын хувьд үйлчилгээ, санхүү, барилга дэд бүтцийн салбаруудын 50%-иас дээш хувьд нь үйл ажиллагаанд нөлөө үзүүлжээ. Харин худалдааны салбарын 46%-д нөлөөлсөн байна. Үйл ажиллагаа хэвийн байсан компаниудын эзлэх хувь өндөр байгаа салбарт мэдээлэл холбоо, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн (ХАА) салбарууд орж байна.

Үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал, корпорэйт



Жижиг, дунд үйлдвэрлэлийн сегментийн хувьд үйл ажиллагаа хэвийн байгаа компаниудын эзлэх хувь 50-иас дээш байгаа нь зөвхөн үйлдвэрлэлийн салбар байна. Тус сегментийн хувьд эрүүл мэндийн салбарын 50%, үйлчилгээний салбарын 42%, барилгын салбарын 40% нь үйл ажиллагаа бүрэн зогсчээ. Нийтдээ жижиг дунд сегментийн 32% нь бүрэн зогссон, 40% нь хэсэгчлэн зогссон, 28% нь үйл ажиллагаа хэвийн байна.


Үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал, ЖДҮ



Тулгарч буй асуудал

Судалгаанд оролцсон байгууллагуудын 47% нь мөнгөн урсгалын, 35% нь ажиллах хүчний, 37% нь бараа материалын дутагдалд орсон гэж хариулсан байна.

Ковидоос үүссэн хүндрэл




Мөнгөн урсгалын дутагдлаа нөхөхийн тулд төлөлтөө хойшлуулах, арилжааны банкнаас зээл авах, үйл ажиллагааны зардлаа бууруулах гэсэн арга хэмжээнүүдийг түлхүү авсан байна. Харин бараа материалын дутагдлаа нөхөхийн тулд татан авалтын шинэ суваг хайх, үйлдвэрлэлийн хэмжээгээ бууруулах, татан авах үнээ нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авсан.

Тэсэх дундаж хугацаа


Корпорэйт сегментийн хувьд одоогийн мөнгөн урсгалаар тэсэх сар өмнөх судалгааны үеэс нэлээд өссөн үр дүн гарсан бөгөөд дунджаар 4.5-иас 9.9 сар болж өссөн байна. Тэсэх сар нь дунджаас өндөр байгаа салбарт бусад хэсэгт, мэдээлэл холбоо, худалдааны салбарууд орж байна.

Тэсэх дундаж хугацаа, корпорэйт



Жижиг, дунд сегментийн хувьд одоогийн мөнгөн урсгалаар тэсэх сар өмнөх судалгааны үеэс 2.7 нэгж хувиар өсөж 5.9 сар болсон байна. Тэсэх сараар дунджаас өндөр байгаа нь уул уурхай, худалдаа, санхүүгийн салбар орж байна.


Тэсэх дундаж хугацаа, ЖДҮ



ААНБ-УУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ААНБ-ууд борлуулалтын орлогыг 2020 онд 11%-иар буурна гэж хүлээж байсан бол 2020 оны гүйцэтгэлээр 20%-иар буурсан. Мөн 2020 оны эцсээр борлуулалт 2021 онд 12%-иар өснө гэсэн хүлээлттэй байсан бол 2021 оны хагас жилийн байдлаар 7%-иар өссөн байна. Энэ төвшнөө хадгална гэж үзвэл жилийн эцсээр борлуулалтын өсөлт хүлээлтээс давах магадлалтай байгаа юм.

Борлуулалтын орлогын дундаж өсөлт




2021 оны хагас жилийн байдлаар борлуулалтын орлого өссөн компаниуд нийт судалгаанд оролцогчдын 54%-ийг эзэлж байсан бол өмнөх онд 46%-ийг эзэлсэн байна. Энэ үзүүлэлтийг 2021 онд 60%-д хүрнэ гэж 2021 оны хагас жилийн байдлаар хүлээж байгаа юм. Харин борлуулалтын орлого буурсан компаниудын эзлэх хувь өмнөх онтой ижил төвшинд буюу 2021 онд 46.4%-г эзэлж байна.

Борлуулалтын орлогын өөрчлөлт



Харин борлуулалтын орлогын өөрчлөлтийг салбараар задлан харвал ХАА, эрүүл мэнд, мэдээлэл холбооны салбарууд 2020, 2021 онд хагас жилээр өсөлттэй байсан. Харин уул уурхай, худалдааны салбарууд нь 2020 онд борлуулалтын орлого буурч байсан бол 2021 хагас жилээр өсөлттэй гарсан байна. 2021 хагас жилийн байдлаар хамгийн өндөр хувиар буурсан салбаруудад тээвэр 20.3%, үйлчилгээ 12%, барилга дэд бүтэц 7 хувиар тус тус буурснаар орсон байна. Харин ХАА салбар 58.3%-ийн борлуулалтын өсөлтөөр бусад салбараас хамгийн өндөр

Борлуулалтын орлогын өсөлт, салбараар




Жижиг, дунд сегментийн хувьд барилга, боловсролын салбарт 2020 онтой харьцуулахад борлуулалтын орлогын хэмжээний бууралт улам нэмэгдсэн байна. Уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, эрүүл мэндийн салбарын борлуулалтын орлого 2021 оны хагас жилийн байдлаар өсөлттэй байна. Эдгээрээс уул уурхай, үйлчилгээ болон худалдааны салбарын борлуулалтын орлого 2020 онд буурч байна.

Судалгаанд оролцсон компаниудын өртөг 2021 оны хагас жилээр 76% байгаа бөгөөд энэ нь 2019 онтой харьцуулахад 6, 2020 онтой харьцуулахад 3 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

Өртөг өсөж байгаа салбаруудад барилга дэд бүтэц, үйлдвэрлэл, худалдаа, тээврийн салбарууд орж байна. Ийнхүү өртгийн хувь өсөж байгаа нь компаниудын цэвэр ашгийн марж буурах гол шалтгаан болж байна.


Дундаж ББӨ хувь



Цэвэр ашиг


Судалгаанд оролцсон ААНБ-уудын цэвэр ашиг 2021 оны хагас жилийн байдлаар 16%-иар өссөн. Салбараар задлан харвал үйлдвэрлэл 356%, тээвэр 193%, ХАА 170%, мэдээлэл холбооны салбар 89%-иар өссөн байна. Харин санхүүгийн салбарын цэвэр ашиг 13%-иар худалдааны салбарын цэвэр ашиг 1%-иар буурсан байна.

Цэвэр ашгийн өсөлт



2021 оны жилийн эцсийн байдлаар борлуулалтын орлогыг дунджаар 11.8%-иар өснө гэсэн хүлээлттэй байгаа бөгөөд үүнд хамгийн өндөр хүлээлттэй салбарт тээвэр 40%, уул уурхай 19%, ХАА-н салбар 25%-иар тус тус багтаж байна. Харин мэдээлэл холбоо, санхүүгийн салбарт борлуулалт өмнөх оноос бараг өөрчлөгдөөгүй байна.


Борлуулалтын орлогын хүлээлт



ХҮНИЙ НӨӨЦӨД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ


Үйл ажиллагааны зардлаа танахын тулд ажилчдаа цомхтгохоос гадна түр цалинтай болон цалингүй чөлөө өгөх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Түр чөлөөлсөн хувь корпорэйт байгууллагын хувьд 5.8 бол жижиг дунд сегментэд 12.6% байна. Цомхтгосон хувь корпорэйт байгууллагад 2.7% бол жижиг дунд сегмент 2%-ийн цомхтгол хийжээ. Харин онлайн ажилчдын хувьд корпорэйт сегментэд ЖДҮ-ээс 2.4 дахин их буюу 13.2% байна.

Хүний нөөцөд гарсан өөрчлөлт



Салбараар нь харахад барилгын салбарын түр чөлөөлсөн хувь хамгийн өндөр буюу 12% бөгөөд ажилчдын цалин 10%-иар, онлайн ажилчдын цалин 72%-иар тус тус буурсан байна. Мөн үйлдвэрлэлийн салбарын цомхтгол болон түр чөлөөлсөн хувь өндөр байна. Барилгаас бусад салбарт биеэр ажиллагсдын цалин буураагүй.


Цалингийн өөрчлөлт



Цалингийн өөрчлөлтийн хувьд корпорэйт байгууллага онлайн ажилчдын цалинг дунджаар 5.5%-р, биеэр ажиллагчдын цалинг 4.8%-иар бууруулсан бол жижиг дунд үйлдвэрлэлийн сегмент онлайн цалинг 15.4%-иар биеэр ажиллагсдын цалинг 2.9%-иар бууруулсан байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГЫН НӨЛӨӨ

Засгийн газрын бодлогын нөлөө



Судалгаанд оролцсон компаниудийн 26% нь Засгийн газрын бодлого үр дүнтэй, 32% нь үр дүнгүй, 41% нь тодорхойгүй гэсэн хариулт өгсөн байна. Бодлогын нөлөөгөөр хамгийн үр дүнтэй байсан салбарт ХАА салбар орсон бөгөөд 67% нь Засгийн газрын бодлого үр дүнтэй байна гэж хариулсан.

Корпорэйт ААНБ-уудын 20% нь Засгийн газрын (ЗГ) бодлого үр дүнтэй байсан гэж хариулсан бол 35% нь үр дүнгүй, 45% нь тодорхойгүй гэж хариулсан байна. Мөн олон удаагийн үр дүн муутай хөл хорио зохион байгуулсан нь бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, барилга угсралтын салбарын хувьд мөнгөн урсгалын дутагдалд орох, үйл ажиллагаа зогссон гэсэн хариулт өгсөн.


Жижиг, дунд секторын хувьд ЗГ-ын бодлогын нөлөө нь 42%-д нь үр дүн үзүүлсэн, 26%-д үр дүнгүй, 32%-д тодорхойгүй гэсэн хариулт өгсөн байна. Корпорэйт секторын хувьд ЗГ-ын бодлогын нөлөө 20%-д нь үр дүн үзүүлсэнтэй харьцуулахад жижиг, дунд секторт бодлогын үр дүн харьцангуй сайн хүрсэн гэж дүгнэж болохоор байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд уул уурхай болон худалдаа, эрүүл мэндийн салбарт ЗГ-ын бодлогын нөлөө бусад салбараас өндөр байна. Санхүү, үйлдвэрлэл, үйлчилгээ, барилгын салбаруудад үр дүнгүй болон тодорхойгүй гэсэн хариулт өндөр хувь эзэлж байна.

ИРГЭДИЙН СЕГМЕНТ ДЭХ НӨЛӨӨ

Иргэдийн сегментийн хувьд 2019 оны 12 сарын байдлаар цалин авч байсан хүмүүсийн дундаж орлого 2020 онд 21%-иар 2021 оны хагас жилд 9%-иар өссөн байна. Дундаж цалингийн орлогын өсөлтөд 2020 онд хэрэгжүүлсэн НДШ болон орлогын албан татвараас чөлөөлөх бодлого

Дундаж цалингийн орлогын өсөлт



Харин иргэдийн зарцуулалт үйлчилгээний салбараас худалдааны салбарт шилжсэн үр дүн гарав. Жишээлбэл, гоо сайхны салоны орлого өмнөх жилээс 10%-иар буурсан бол гоо сайхны дэлгүүрийн орлого 52%-иар өссөн байна.

Үзвэр үйлчилгээний орлого 66%-иар буурсан бол цахилгаан бараа, компьютерын худалдаа 55%-иар өссөн.


40

Эмнэлгийн орлого 13%-иар эмийн сан 35%-иар өссөн бол л эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдаа 11%-р буурсан байна.

Мөн бэлэн хувцасны худалдааны орлого 29%-иар, гутал хувцас засварын үйлчилгээний орлого 43%-иар өссөн байна.

Хамгийн өндөр өсөлт үзүүлсэн төрөлд 43%-ийн өсөлтөөр хүнсний дэлгүүрийн борлуулалт орж байна.

Иргэдийн хэрэглээийн хандлага



Ерөнхий дүгнэлт

2020 онд коронавирусын нөлөө эдийн засагт илүү хүчтэй байсан бол 2021 оноос эхлэн борлуулалт, цэвэр ашиг өсөлт үзүүлсэн байна. 2021 оны хагас жилийн байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх оноос сайжирсан хэдий ч энэ нь 2020 оны эцсээр хүлээж байсан үр дүнд хараахан хүрээгүй байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад коронавирусээс үүдсэн айдас, хүлээлт арилж дасан зохицож эхэлснээс гадна Засгийн газрын мөнгөний тэлэх бодлого, тэр дундаа репо зээл, ажлын байр дэмжих зээл зэрэг хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл банкнуудаар дамжуулан компаниудад олгосон нь банкны систем дэх зээлийн үлдэгдлийг өсгөж гадна компаниудын санхүүгийн хүндрэл буурахад нөлөөлсөн байна.

Жижиг, дунд болон корпорэйт сегментийн аль алинд илүү хүндэрсэн нь барилга дэд бүтцийн салбар байна.

Худалдааны салбарын хувьд борлуулалтын орлого өссөн ч өртгийн хувь өссөн, цэвэр ашгийн жилийн өсөлт сөрөг гарсан зэрэг нь шатахууны үнийн өсөлт, тээврийн зардал, хил гаалийн гацалт зэрэг гол зардлууд өссөнтэй холбоотой байна. Тус секторт үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ууд алдагдлаас зайлсхийхийн тулд борлуулах бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж, энэ нь эргээд зах зээлд огцом үнийн өсөлт үүсгэх магадлал өндөр гэж таамаглаж байна.

Иргэдийн хувьд дундаж цалингийн орлого өсөлттэй хэдий ч өсөлтийн хувь саарсан. Хэрэглээний хувьд үйлчилгээнээс илүү худалдааны байгууллагын бүтээгдэхүүн түлхүү хэрэглэх болсон өөрчлөлт гарав.

ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

Түүвэр судалгаанд хамрагдсан ААНБ-уудын тоо болон бүтэц

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал	Корпорэйт		Жижиг дунд		Нийт	
	2020	2021	2020	2021	2020	2021
Барилга & ДБ	17	16	5	2	22	18
Бусад	3	0	0	0	3	0
Мэдээлэл холбоо	2	2	0	0	2	2
Санхүү	4	2	6	5	10	7
Тээвэр	8	6	0	0	8	6
Уул уурхай	13	11	2	2	15	13
Үйлдвэрлэл	21	15	7	6	28	21
Үйлчилгээ	7	8	12	12	19	20
Эрүүл мэнд	1	3	4	4	5	7
ХАА	3	3	0	0	3	3
Худалдаа	52	44	16	12	68	56
Нийт	131	110	52	43	183	153

Хавсралт №2

ҮСХ-н стандарт ангилал	Ковид-н судалгаа
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Санхүү
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээ	Худалдаа
Уул уурхай, олборлолт	Уул уурхай
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Үйлчилгээ
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Үйлчилгээ
Барилга	Барилга & ДБ
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	Тээвэр
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Барилга & ДБ
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	Бусад
Мэдээлэл, холбоо	Мэдээлэл холбоо
Боловсруулах үйлдвэрлэл	Үйлдвэрлэл
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Бусад
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Үйлчилгээ
Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээ
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Үйлчилгээ
Боловсрол	Боловсрол
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Үйлчилгээ
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	ХАА



Тэмдэглэл

Blank lined area for notes.

Handwriting practice lines consisting of 20 horizontal dotted lines.

ТАЛАРХАЛ

FMC-2021 арга хэмжээний “Монголын эдийн засаг” сэдвийг хамтран бүтээлцсэн дараах эрхэм зочиддоо талархал илэрхийлье.

Д.Жаргалсайхан /DeFacto/
Н.Энхбаяр /Эдийн засагч/
Ч.Хашчулуун /Эдийн засагч/
Б.Баярдаваа /Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал/

FMC арга хэмжээний “Хөрөнгийн зах зээл” сэдвийг бүтээхэд хамтран ажилласан “Голомт Капитал” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.

Голомт капитал ХХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ соёлыг түгээхээр зорин ажилладаг ба андеррайтер, брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг гадаад дотоодын харилцагч, түнш, хамтран ажиллагч харилцагч байгууллагууддаа хүргэж ирсэн.

2018 онд Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн давхар бүртгэлийн (FPO) туслах андеррайтераар, даатгалын зах зээлд тэргүүлэгч “Мандал Даатгал” ХК-ийн IPO үндсэн андеррайтераар, 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч “Түмэн Шувуут” ХК-ийн IPO үндсэн андеррайтераар, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч “Монос Хүнс” ХК-ийн IPO үндсэн андеррайтераар тус тус ажиллаж, 2021 онд конвинеенс дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХХК-ийн (CU) IPO андеррайтераар ажиллаж буй андеррайтерийн үйлчилгээгээр зах зээлд тэргүүлэгч компани юм.

2015 онд Монгол Улсын анхны даатгагдсан бонд болох “Эрчим” бонд, 2017 онд анхны нээлттэй бонд болох “Сүү” бонд, 2020 онд анхны хайбрид бонд болох “Мастер” бонд, анхны 100 хувийн банкны баталгаат бонд болох “Нөмөр” бонд, 2021 онд биржийн бус зах зээлийн анхны бонд болох “Монкон” бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай. 2021 оны 10-дугаар сарын 10-ны байдлаар биржийн бус зах зээлийн нийт бондын 57%-ийн андеррайтерийн үйлчилгээг дангаар гүйцэтгэж, биржийн бус зах зээлийн бондын андеррайтерийн үйлчилгээгээр тэргүүлж байна.

Монголд анхлан онлайн арилжааны систем нэвтрүүлснээс гадна харилцагч гар утаснаасаа анхдагч арилжаанд оролцох боломжтой “SocialPay” аппликэйшн, хүссэн цагтаа (24/7) гадаадын хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлсэн “Interactive Brokers” үйлчилгээг албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлсэн.



Энхтайваны гүүрний зүүн хойд талд, “Park Place” оффис, 4 давхар 403 тоот



7012-1530

АНХААРУУЛГА

Энэхүү номыг нь Голомт банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд харилцагчийн мэдээллийг хамгаалан хийсэн. Мөн номонд тусгасан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй бөгөөд судалгаанд үндэслэсэн шийдвэр гаргалтад хариуцлага хүлээхгүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.

Байгууллагын банкны газар:

И-мэйл хаяг: corporatebanking@golomtbank.com
Корпорэйт лавлах утас: 7011-7676

Үйлдвэр худалдааны хэлтэс: 7575-1111 (1403)
Бизнес хамтын ажиллагааны хэлтэс: 7575-1111 (1212)
Уул уурхай, дэд бүтцийн хэлтэс: 7575-1111 (1210)

Нөөцийн удирдлагын газар:

И-мэйл хаяг: forex@golomtbank.com
Арилжааны хэлтэс: 7555-3434

Эдийн засгийн судалгааны алба:

И-мэйл хаяг: eru@golomtbank.com
Утас: 7575-1111 (1277)

Хаяг: Голомт банкны Төв байр,
Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол улс

Swift: GLMTMNUB